



НИЙСЛЭЛИЙН ОНЦГОЙ КОМИССЫН ХУРЛЫН ТЭМДЭГЛЭЛ

2021 оны 11 сарын 23 өдөр

Дугаар 20

Улаанбаатар хот

ШУУРХАЙ ШТАБЫН ЦАХИМ ХУРЛЫН ТЭМДЭГЛЭЛ

Нийслэлийн Онцгой комиссын Шуурхай штабын цахим хурал 2021 оны 11 дүгээр сарын 23-ны өдрийн 19:30 цагт гишүүдийн 90 хувийн ирцтэй хуралдав.

ХЭЛЭЛЦСЭН НЬ:

Хурлыг Нийслэлийн Онцгой комиссын Шуурхай штабын дарга Р.Дагва даргалж, “Коронавируст халдвар (Ковид-19)-ын эсрэг дархлаа сэргээх нэмэлт тунгаар вакцинжуулах үйл ажиллагааг эрчимжүүлэх төлөвлөгөө”, дархлаажуулалтын цэг нэмж ажиллуулах талаар хэлэлцэж холбогдох асуудлаар үүрэг чиглэл өгөв.

ШИЙДВЭРЛЭСЭН НЬ:

Нэг. Нийслэлийн нутгийн захиргааны байгууллагын удирдлагуудад

1.1. Нийслэл, дүүргийн нутгийн захиргааны байгууллагын албан хаагчдад ажлын нэг өдрийн чөлөө олгож, дархлаажуулалтын нэмэлт тунд хамруулах зохион байгуулалтын арга хэмжээг авч, хамрагдаагүй шалтгааны талаарх судалгааг 2021 оны 12 дугаар сарын 03-ны өдрийн дотор nok@ulaanbaatar.mn цахим хаягт ирүүлэх.

Хоёр. Нийслэлийн Эрүүл мэндийн газар, Дүүргүүдийн Эрүүл мэндийн төвийн дарга нарт

2.1. Эм эмнэлгийн хэрэгслийн нөөцийг нарийвчлан шалгаж тогтоон, 3 сарын хугацааны хангалтын бэлэн байдлыг бүрдүүлж танилцуулах.

Гурав. Багахангай, Багануур, Налайх, Хан-Уул, Сонгинохайрхан дүүргийн Онцгой комиссын дарга нарт

3.1. Иргэдийн дархлаа сэргээх нэмэлт тунгийн хамрагдалтыг сайжруулах чиглэлээр хороо, өрхийн эрүүл мэндийн төв, хэсгийн ахлагч нарын ажлыг эрчимжүүлж, урамшуулалт аян зарлан, үр дүнг тооцож ажиллах.

Дөрөв. Дүүргүүдийн Онцгой комиссын дарга нарт

4.1. Нийслэлийн 9 дүүргийн хороодод /171/ дархлаажуулалтын цэг ажиллуулах байрны халдвар хамгаалал, орчин нөхцөл, бэлэн байдлыг хангуулж, хороодын хүн амыг идэвхтэй хамруулах ажлыг хорооны Засаг дарга, түүний Ажлын албад хариуцуулан дэмжлэг үзүүлж, зохион байгуулалтын арга хэмжээ авах;

4.2. Хорооны байргүй хороодод (2021 он дуустал) дархлаажуулалтын цэг ажиллуулах түрээсийн байрны төлбөр тооцоо, судалгааг яаралтай гаргаж, Нийслэлийн Онцгой комиссын Шуурхай штабын nok@ulaanbaatar.mn цахим хаягт 2021 оны 11 дүгээр сарын 25-ны өдрийн дотор ирүүлэх;

4.3. Нийслэлийн дүүргүүдийн нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж байгаа аж ахуй нэгж байгууллагын судалгааг гаргаж, тэдгээрийн ажилтан, албан хаагчдыг дархлаажуулалтын нэмэлт тунд хамруулах ажлыг зохион байгуулах.

Тав. Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын
Хэвлэл мэдээлэлтэй харилцах хэлтэс,
Дүүргүүдийн Онцгой комиссын дарга нарт

5.1. Дархлаажуулалтын нэмэлт цэг, суурин цэг болон түр цэгийн байршлын мэдээллийг иргэд, олон нийтэд хүргэж, хаягжуулалтын ажлыг шуурхай зохион байгуулж 2021 оны 11 дүгээр сарын 30-ны дотор танилцуулах.

ШУУРХАЙ ШТАБЫН
ДАРГА



Р.ДАГВА